



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 06 өдөр

Дугаар А/127

Хэрлэн сум

Сургалтад хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.5, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 15 дугаар хуралдааны 06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутагт төрийн захиргааны албан хаагчдын сул орон тоог нөхөх, хот хөдөөгийн сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор “Шударга төрийн төлөө ТББ”-тай хамтран төрийн албаны ерөнхий шалгалтад бэлтгэгчдэд зориулсан сургалтыг зохион байгуулахад 8,302,000 (найман сая гурван зуун хоёр мянга) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.
2. Шаардагдах зардлын тооцоог хавсралтаар баталсугай.
3. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д даалгасугай.
4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

Аймгийн Засаг даргын 2023 оны
дугаар сарын 06-ны өдрийн
дугаар захирамжийн хавсралт



ЗАРДЛЫН ТООЦОО

№	Зардлын нэр	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт үнэ
1.	Сургалтын зардал	35	237200	8302000
	Нийт			8302000